

**БИЕТ АЛТНЫ ФОРВАРД АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТИЙН ГЭРЭЭ**

2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр № БГК 080-03-24-01 Улаанбаатар хот

Энэхүү Биет алтны форвард арилжааны гэрээний нэмэлт, өөрчлөлтийн гэрээ (цаашид “Нэмэлт гэрээ” гэх)-г

Нэг талаас Энхтайвангийн өргөн чөлөө 19, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14210, Монгол Улс хаягт орших [REDACTED] (цаашид “Банк” гэх),

Нөгөө талаас Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвангийн өргөн чөлөө, Блю ский тауэр 7-р давхар хаягт орших Бороогоулд ХХК (РД: 2094533) (цаашид “харилцагч” гэх) (хамтад нь “талууд” гэх) дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож энэхүү нэмэлт гэрээг байгуулав.

Нэг. Нэмэлт, өөрчлөлт

1.1. Энэхүү гэрээний дагуу талуудын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн №БГК 080-03-24 дугаар “Биет алтны форвард арилжааны гэрээ”-ний дараах зүйл заалтуудад нэмэлт, өөрчлөлтийг оруулав. Үүнд:

1.1.1. Үндсэн гэрээний 2.1.1-д “Форвард арилжаа хийгдэх хугацаа: 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл” гэснийг

2.1.1 “Форвард арилжаа хийгдэх хугацаа: 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл” гэж өөрчлөв.

1.1.2. Үндсэн гэрээний 2.6-д “Хэрэв сүүлийн 2 сарын байдлаар 2.4-д заасан хэмжээний алтыг банканд тушаагаагүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувийн алдангийг банканд төлнө.” гэснийг хасав.

Хоёр. Бусад зүйл

2.1. Энэ гэрээг 2 хувь үйлдэж, хоёр тал тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

2.2. Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бусад Үндсэн гэрээний зүйл заалтууд хүчин төгөлдөр хэвээр болно.

2.3. Талууд гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэх, дамжуулах, худалдахыг хориглоно.

Гэрээ байгуулсан:

Банкийг төлөөлж:



Худалдагчийг төлөөлж:

